

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН НЭГ ГАРЦ БОЛ ОХУ-ЫН СИБИРИЙН БҮС НУТАГ МӨН

*Х.Мандухай**

Олон арван жилийн найрсаг харилцааны баялаг түүхтэй манай хоёр орон, ард түмнийг өнөөдөр ардчилал, шинэчлэлийн олон төрлийн ижил төстэй зорилтууд, харилцан шүтэлцээтэй хамтын ажиллагааны ашиг сонирхол холбож буй. Манай орны ойрын 5-10 жилийн хөгжилд ОХУ-тай тогтоосон эдийн засаг, боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухаан, соёлын салбарын хамтын ажиллагааны үүрэг роль улам өсөн нэмэгдэх төлөвтэй байна. Ялангуяа Орос, Монголын хил орчмын бүс нутаг, субъектүүд хоорондын хэлхээ холбоо, харилцан ажиллагааг бүхий л талаар өргөжүүлэн хөгжүүлэх боломж их бий юм. Энэ нь хоёр орны харилцааны өнөөгийн болон цаашдын шинж төрхийг тодорхойлох гол хүчин зүйл мөн.

Бүс нутгийн харилцаа бол улс төрийн гэхээсээ эдийн засаг, соёл иргэншлийн үнэт зүйлд илүү тулгуурласан, бие биеэс нь салгаж болшгүй бодит шүтэлцээ, харилцан хамаарлыг шингээн илэрхийлж, хүмүүнлэгийн хүчин зүйлд шууд чиглэсэн тасралтгүй үргэлжилсэн хөдөлгөөнт чанарыг агуулж байдгаараа хөрш орнуудын хөгжлийн чухал зүй тогтолт үйл явц мөн. Энэхүү бодит зүй тогтлыг танин мэдэж, мөн чанарыг нь нээхийн хэрээр, шилж сонгодоггүй, салгаж болдоггүй хөршүүдийн хамтын ажиллагааг зах зээлийн харилцааны шинэ нөхцөлд нийцүүлэн бие биедээ оршихуй, хөгжихүйн хүчин зүйл болж байх бодит агуулгын түвшинд нь хүртэл идэвхжүүлж өргөжүүлэх шаардлага буй нь тодорхой.

1990 оны эхнээс Монгол, Оросын харилцаа хуучин тогтолцооны задралын давалгаанд өртөн ерөнхийдөө үлэмж суларч саарсан хэдий ч бүс нутаг, субъектуудын уламжлалт шууд харилцаа нэг их тасалдаагүй.

2000 оны 11 дүгээр сард ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путины манай оронд хийсэн айлчлалын үеэр “Монгол Улсын орон нутгийн засаг захиргаад, ОХУ-ын субъектуудын гүйцэтгэх засаглалын байгууллагуудын хоорондын хамтын ажиллагааны зарчмуудын тухай”¹ хэлэлцээрт гарын үсэг зурсан явдал нь Монгол, Оросын хил орчим, бүс нутаг, субъектуудын харилцаа, хамтын ажиллагааны эрх зүйн үндсийг бэхжүүлэхэд ач холбогдолтой болсон юм.

Бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагаанд болон манай улсын хөгжлийн үйлсэд ОХУ-ын Сибирийн бүс нутаг маш чухал үүрэг рольтой байх төлөв ажиглагдаж байгаа. Чухам энд хоёр талын хамтын ажиллагааны ашиглагдаагүй үлэмж их нөөц байна гэж хэлж болно.

Нийт 6,5 сая кв буюу ОХУ-ын нутаг дэвсгэрийн 38-тай тэнцэх өргөн уудам талбайг эзэлдэг, 25 сая орчим хүн ам бүхий 2 хязгаар, 7 муж, 4 БНУ, үндэсний 5 тойрогт хуваагддаг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн өвөрмөц бүтэцтэй Сибирь нутаг бол ОХУ-ын бүсчилсэн хөгжлийн стратегийн нэг гол төв юм.

* Х.Мандухай - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан

Эдүүгээ байгалийн нөөцөөрөө баян байх тусмаа гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг төдийчинээ татах их боломжийг улс орондоо олгож байдаг тийм бүс нутгууд эдийн засгийн стратегийн төвд тавигдах болов. Иймээс ч эрчим хүч, шатдаг хий, нефть, ойн асар их баялаг, хөрсөн доорхи эрдсийн арвин сан, Байгаль нуур хэмээх цэнгэг усны нөөцөөрөө алдартай Сибирийн бүс нутгийг хөгжүүлэх асуудал ОХУ-ын засгийн бодлогын тэргүүлэх чиглэлийн нэг болж байна.

Сибирийн бүс нутаг, түүний субъектуудын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх, бүс нутаг хооронд интеграцчлах чиглэлийг боловсруулахад 1991 оны 2-р сард байгуулагдсан “Сибирийн зөвшилцөл” /Сибирское соглашение/² хэмээх бүс нутаг хоорондын холбоо, ялангуяа 2000 оноос эхлэн тогтмол зохиогдож буй “Байгалийн эдийн засгийн чуулга” уулзалтууд чухал үүрэг гүйцэтгэж байна.

“Сибирийн зөвшилцөл” холбооны дүрэмд “Энэхүү холбоо нь мөрийн хөтөлбөр, төслүүдийн үндсэн дээр Сибирийн үйлдвэрлэл, эдийн засаг, шинжлэх ухаан техникийн болон нийгмийн хөгжилд оролцогч субъектуудын эдийн засгийн хамтын ажиллагаа, бүс нутаг хоорондын интеграцийг хөгжүүлэх зорилготой байгууллага мөн” гэж заажээ. Тус холбоо нь эдийн засаг, шинжлэх ухаан, техник, соёл, хөдөө аж ахуй, эрчим хүч, гадаад харилцаа, байгалийн нөөц, зэрэг тодорхой асуудал хариулсан зохицуулах зөвлөл байгуулж ажиллуулдаг бөгөөд тэдгээр нь бүс нутгийг хөгжүүлэх асуудлаар зөвлөмжийн чанартай шийдвэр гаргадаг юм байна.

Сибирийг хөгжүүлэх бодлогын хүрээнд байгалийн нөөц баялаг, газар зүйн ашигтай байрлал бүхий энэ бүс нутгуудыг дэлхийн хамтын нийгэмлэгийн интеграци үйл явцад оролцуулахад их анхаарч байгаа. Сибирь нь нутаг дэвсгэр уудам тархмал, зам харилцаа харьцангуй дутмаг хөгжсөн, хүн амын нягтрал бага /1 км²-д 2-4 хүн/ хэдий ч өнгөрсөн зууны үед эдийн засгийн хөгжлийг хурдасгах, далайцтай бүтээн байгуулалтыг өрнүүлэх үлэмж чадавхитай, боломжтойг нээн харуулсан туршлагатай юм. Жишээ нь: Назаровск, өмнөд Кузбассын томоохон цахилгаан станцууд, Братск, Иркутск, Красноярск, Новосибирск, Саянск, Усть-Илимск зэрэг усан цахилгаан станцууд баригдсан. Олон хот, суурин газруудыг холбосон төмөр зам, алдарт Байгаль-Амарын гол зам зэргийг барьж байгуулснаар төмөр замын өргөн сүлжээ үүссэн. Туймазаас Ангарск руу, Сургутаас Омск хүртэл нефть дамжуулах хоолой, Баруун хойт Сибирээс ОХУ-ын Европын хэсэг руу шатдаг хийн дамжуулах хоолой барьж байгуулсан. Сибирь нутаг түүхий эд, өнгөт металлаар дэлхий хэмжээний ач холбогдол бүхий асар их нөөцтэй. Эдүүгээ Сибирьт Оросын түлш, эрчим хүчний нөөцийн 80%, түүний дотор нефтийн нөөцийн 77%, шатдаг хий 92%, нүүрсний 65% нь үйлдвэрлэгдэж байна. Сибирийн хөрсөнд нийт Оросын ашигт малтмалын нөөцийн 70% орчим нь агуулагдаж байна.³ “Сибирийн зөвшилцөл” бүс хоорондын Холбооны дүгнэснээр тэрхүү байгаль-эрчим хүчний нөөц чадавхи нь “Бүс нутаг ба улс орны эдийн засагт онцгой ач холбогдолтой. Түүний үндсэн дээр Оросын эдийн засгийн аюулгүй байдал олон талаар

хангагдаж, дэлхийн аж ахуйн системд оролцох дагнасан чиглэл нь тодорхойлогдож, улс орны валютын орлогын тэн хагас нь хангагдаж байна”.⁴

ОХУ-ын ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх бүс нутгуудын гүйцэтгэх шууд засаглалыг бэхжүүлэх, нийгэм эдийн засгийн хөгжлийг төрийн зүгээс зохицуулах зорилгоор 2000 онд Оросын бүх нутагт холбооны 7 тойрог байгуулж тэдгээрт ерөнхийлөгчийн бүрэн эрхт төлөөлөгч ажиллуулах болсны нэг нь Новосибирск төвтэй Сибирийн тойрог юм.

Сибирийн тойрог нь нутаг дэвсгэрийнхээ хэмжээгээрээ, хүн амын тоогоороо ч бусад бүс, эдийн засгийн районуудын дотор тэргүүлэх байр эзэлдэг. Бас усан замын өндөр хөгжсөн сүлжээтэй. Усан онгоц явдаг хамгийн том гол нь Монголын нутгаас эх авдаг Обь, Иртыш юм. Усан замын өргөн сүлжээ нь бүс нутгийн дотоодын хүн тээвэр, ачаа тээврийг гүйцэтгэх төдийгүй Сибирь болон Алс Дорнодын хойт нутгуудыг хөгжүүлэх эдийн засаг, стратегийн асар их ач холбогдолтой юм.

Энэ бүхэн нь тус бүс нутгийн нийт Орос орны эдийн засгийн хөгжилд эзлэх байр, үүрэг нөлөөг тодорхойлж байна. Тиймд ОХУ-ын Засгийн газар 2002 оны 6-р сард “Сибирийн эдийн засгийн хөгжлийн стратеги”⁵ баримт бичиг гаргаад хэрэгжүүлж байгаа юм. Түүндээ Хятад, Казакстан, Киргизстаны нэгэн адил манай улстай харилцах хилийн хамтын ажиллагааны чухал чухал асуудал тусгаж оруулсан байгаа.

Бүс нутгийн аж үйлдвэр, ялангуяа түүний тэргүүлэх салбар болсон хар ба өнгөт металлурги, химийн болон нефть, байгалийн хийн аж үйлдвэр нь гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхлыг ихээхэн татаж буй. Бүс нутгийн аж үйлдвэрт гадаадынхны хөрөнгө оруулалтын хэмжээ сүүлийн жилүүдэд мэдэгдэхүйц өсч байна. Үүнээс гадна Новосибирск, Иркутск зэрэг олон муж, хот Оросын төдийгүй дэлхийн, зүүн хойт Азийн нутгийн боловсрол, шинжлэх ухааны томоохон төв болсон хийгээд оюуны салбарын хөрөнгө оруулалтаар баялаг туршлага хуримтлуулсан байгаа.

Энэ бүхнийг энд онцлон дурдахын учир гэвэл: Монгол Улсын ойрын 5-10 жилийн хөгжилд ОХУ-ын үзүүлэх гол нөлөөлөл, эдийн засгийн гол хүчин зүйл нь чухамхүү энэ Сибирь нутаг мөн. Түүнчлэн Монгол-Оросын харилцаа, хамтын ажиллагааг энэ жилүүдэд эрчимтэй, тогтвортой, үр ашигтай хөгжүүлэх хамгийн гол тэргүүлэх цөм нь ч энэ бүс нутаг мөн юм.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. “Монгол Улс, Оросын Холбооны Улсын харилцаа, хамтын ажиллагааны баримт бичгийн эмхтгэл”. 182 дахь тал. УБ.2006
2. “Сибирийн зөвшилцөл” холбоонд Алтай, Красноярскийн хязгаар, Хакас, Тыва, Буриад, Омск, Томск, Новосибирск, Эрхүү, Кемеров, Чита муж зэрэг нийт 19 субъект нэгдэн ордог байна.
3. Науки в Сибири. Октябрь 2008 г., №38
4. Мир и Россия на пороге XXI века. Вторые Горчаговские чтения. М., РОССПЭН, 2009 г., с.543
5. Официальные документы “Стратегия развития экономики Сибири РФ”, м 2006.